НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА БОЛОН НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА ХООРОНДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

БАРИМТЖУУЛАЛТ

	Албан тушаал, нэр, гарын үсэг	Огноо
БАТАЛСАН	“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ	2025.07.21
ХЯНАСАН	АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА П.ГАНТӨГС	2025.07.21
БОЛОВСРУУЛСАН	АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Д.БАЯРТОГТОХ	2025.07.21

АГУУЛГА

АГУУЛГА 1
ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ 2
1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ 3
1.1 Зорилго 3
1.2 Талууд 3
1.3 Зохицуулалтын баримт бичгүүд 3
1.4 Хүчинтэй хугацаа 4
1.5 Нэр томьёо, тодорхойлолт 4
1.6 Товчилсон үсгийн тайлбар 4
1.7 Цаг хугацааны формат 5
2. НИСЭХИЙН ӨГӨГДӨЛ, НИСЭХИЙН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ 5
2.1 Томилогдсон мэдээлэгчийн үүрэг хариуцлага, үйл ажиллагаа 5
2.2 НМҮБ-ын үүрэг хариуцлага, үйл ажиллагаа 6
2.3 Нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийн алдаа 6
2.4 Нөөц төлөвлөгөө 7
3. БУСАД 7
3.1 Журмын хэрэгжилтийг үнэлэх 8
3.2 Үл нийцлийг мэдээлэх 8
3.3 Журмыг хариуцагчид 8
3.4 Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах 9
3.5 Бусад зохицуулалтууд 9
3.6 Томилогдсон ажилтнууд 9
ХАВСРАЛТ 1 - ЦАГИЙН ХЯЗГААР (TIMELINESS) 10
ХАВСРАЛТ 2 – НИСЭХИЙН ӨГӨГДӨЛ, НИСЭХИЙН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ХЭРЭГСЭЛ 11
ХАВСРАЛТ 3 – ТҮҮХИЙ ӨГӨГДӨЛ ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ 12
ХАВСРАЛТ 4 - RAW DATA ПРОГРАММ АШИГЛАДАГ ТОМИЛОГДСОН МЭДЭЭЛЭГЧДИЙН БҮРТГЭЛ 13

ИНҮТ-АБЧҮГ №01
ХЯНАЛТТАЙ

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Өөрчлөлтийн дугаар	Хэвлэсэн огноо	Өөрчлөлтийн товч утга	Хамаарах хуудас
01	2024.07.30	ИНЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн А/382 дугаар, 2023 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн А/398 дугаар тушаалуудаар тус тус ИНҮТ-ийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан нэмэлт өөрчлөлт оруулсан. Тогтмол шинж чанартай АІР зарлуулах мэдээллийг хассан.	Бүгд
02	2025.06.18	“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ний зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт болон ИНЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний А/144 дугаар тушаалаар батлагдсан “Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах ерөнхий журам”-д нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой өөрчлөлтүүдийг оруулж боловсруулав.	Бүгд

ИНҮТ-АБЧУГ №01
ХЯНАЛТТАЙ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Зорилго

1.1.1 Энэхүү харилцан ажиллагааны зохицуулалтын журмын зорилго нь Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба (цаашид томилогдсон мэдээлэгч гэх)-аас Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах үйл ажиллагаа болон харилцан ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Талууд

1.2.1 Талууд болон тэдгээрийн үүрэг, хариуцлагыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Талууд	Хаяг	Хуулийн этгээд	Үүрэг, хариуцлага
Томилогдсон мэдээлэгч: Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба	Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба Буянт-Ухаа ОУНБ Ш/х- Улаанбаатар 17120 Монгол Улс	НУТА-ны дарга Т.Батбаяр	Томилогдсон мэдээлэгч нь энэхүү зохицуулалтын дагуу НМҮБ-ыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангана.
Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага (НМҮБ): Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба Буянт-Ухаа ОУНБ Ш/х-59 Улаанбаатар 17120 Монгол Улс	НМҮА-ны дарга Д.Үлэмж	НМҮБ нь томилогдсон мэдээлэгчийн хангасан нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүнийг боловсруулан түгээнэ.

1.3 Зохицуулалтын баримт бичгүүд

1.3.1 Энэхүү харилцан ажиллагааны зохицуулалтын журмыг ИНЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний А/144 дугаар тушаалаар батлагдсан "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах ерөнхий журам"-ийг үндэслэн боловсруулсан болно.

1.3.2 Нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг үүсгэх, цуглуулах, боловсруулан түгээх үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтуудыг дараах ICAO-ийн болон үндэсний зохицуулалтын баримт бичгүүдэд тусгасан. Үүнд:

a. Annex 2 – *Rules of the Air;*

b. Annex 11 – *Air traffic Services;*

c. Annex 15 — *Aeronautical Information Services;*

d. Procedures for Air Navigation Services — ICAO Abbreviations and Codes (PANS-ABC, Doc 8400);

e. Procedures for Air Navigation Services — Aeronautical Information Management (PANS-AIM, Doc 10066)

f. Doc 7910 "Location Indicators";

g. Doc 8126 "Aeronautical Information Services Manual";

ХЯНАЛТТАЙ

h. Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах ерөнхий журам;

i. Нисэхийн мэдээллийн үйлчилгээний Үйл ажиллагааны ерөнхий заавар.

1.4 Хүчинтэй хугацаа

1.4.1 Энэхүү харилцан ажиллагааны зохицуулалтын журам "ИНҮТ" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд албан ёсоор хүчингүй болгох хүртэл энэхүү журам хүчин төгөлдөр байна

1.4.2 Талууд харилцан тохиролцсон тохиолдолд энэхүү журмыг хүчингүй болгож болно. Журмыг хүчингүй болгох саналаа хүчингүй болгох хугацаанаас 30-аас доошгүй хоногийн өмнө албан бичгээр нөгөө талдаа АНҮГ-т мэдэгдэнэ.

1.5 Нэр томьёо, тодорхойлолт

1.5.1 Энэхүү журамд "ИНД-ийн нэр томьёоны тайлбар" болон "MNS 6409:2024 Иргэний нисэх.Ерөнхий нэр томьёо, тодорхойлолт"-д тусгагдсан болон дараах нэр томьёо, тодорхойлолтуудыг ашиглана. Үүнд:

a) "Томилогдсон мэдээлэгч" гэж энэхүү зохицуулалтын дагуу Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах үүрэг хариуцлага бүхий байгууллага эсхүл албан тушаалтныг хэлнэ

b) "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага" гэж энэхүү зохицуулалтын дагуу нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг хүлээн авах, боловсруулах, түгээх үүрэг хариуцлага бүхий байгууллагыг хэлнэ.

c) "Өгөгдөл" гэж энэхүү зохицуулалтын дагуу томилогдсон мэдээлэгчийн хариуцан, хангах нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээлийг хэлнэ

d) "Талууд" гэж Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага болон Томилогдсон мэдээлэгчийг хэлнэ.

1.6 Товчилсон үсгийн тайлбар

1.6.1 Энэхүү зохицуулалтын баримт бичигт дараах товчилсон үгсийг ашиглана. Үүнд:

- ИНД Иргэний нисэхийн дүрэм
- АНҮГ Агаарын навигацийн үйлчилгээний газар
- НМҮ Нисэхийн мэдээллийн үйлчилгээ
- НМҮА Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба
- НМҮБ Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага
- НУТА Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба
- НЦХЗХ Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсэг
- ТМХ Тогтмол мэдээллийн хэсэг
- БХХ Бүтээгдэхүүн хяналтын хэсэг
- ТоМХ Тоон мэдээллийн хэсэг

ИНҮТ-АБЧҮГ №01
ХЯНАЛТТАЙ

- ЗБТ Зургийн боловсруулалтын тасаг
- ШМХ Шуурхай мэдээллийн хэсэг
- AIP Aeronautical information publication
- AIRAC Aeronautical information regulation and control
- ICAO International Civl Aviation Organization
- AFS Нисэхийн суурин үйлчилгээ
- IFR Instrument flight rule

1.7 Цаг хугацааны формат

1.7.1 Энэхүү зохицуулалтын дагуу явагдах үйл ажиллагаанд Annex 5-д тусгагдсан олон улсын цаг (UTC)-ийг ашиглана. Огноо, цагийг Annex 5, Attachment E-д заасны дагуу тоон хэлбэрээр бичнэ.

Жишээ нь 2024 оны 12 сарын 14-ний 08 цаг 15 минутыг 2024-12-14 16:15 гэж бичнэ.

2. НИСЭХИЙН ӨГӨГДӨЛ, НИСЭХИЙН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

2.1 Томилогдсон мэдээлэгчийн үүрэг хариуцлага, үйл ажиллагаа

2.1.1 Томилогдсон мэдээлэгч нь НМҮБ-ыг цаг хугацаанд нь нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах үүрэгтэй.

2.1.2 Томилогдсон мэдээлэгч нь нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийн хүчинтэй байдлыг хариуцах бөгөөд нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээлэлд өөрчлөлт орох бүрд НМҮБ-ыг мэдээллээр хангаж хамтран ажиллана.

2.1.3 Томилогдсон мэдээлэгч нь НМҮБ-ыг дараах өгөгдлүүдээр хангана.

a) түр шинж чанартай, NOTAM-аар зарлах өгөгдөл;

b) түр шинж чанартай шуурхай мэдээгээр зарлах өгөгдөл;

2.1.4 Түр шинж чанартай, NOTAM-аар зарлах өгөгдлөөр хангах

2.1.4.1 Томилогдсон мэдээлэгч нь дараах түр шинж чанартай, богино хугацаатай (3 сараас бага хугацаатай), урт текст, график агуулаагүй NOTAM-аар гаргах өгөгдлөөр НМҮБ-ыг хангана.

NOTAM код	Өгөгдөл/мэдээлэл
SL	Урсгал хяналтын төв Flow control centre

2.1.5 Түр шинж чанартай шуурхай мэдээгээр зарлах өөрчлөөр хангах

2.1.5.1 Томилогдсон мэдээлэгч нь түр шинж чанартай, AIP-ийн нэмэлтээр хэвлэн нийтлэгдэхгүй, NOTAM-аар зарлагдахгүй боловч зайлшгүй мэдээллэх шаардлагатай өөрчлүүд (цахилгаан хангамж, халаагч, утас, факс гэх мэт)-ээр хангана.

2.1.6 Нислэгийн урсгал төлөвлөлтийн урьдчилсан болон шуурхай төлөвлөлтийн мэдээллээр НМҮБ-г хангаж ажиллана.

2.1.7 Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээг ажлын өдрийн 18:00 цагт багтаан НМҮБ-д aiszmck@ncac.mn, aiszmub@ncac.mn цахим шуудангийн хаягаар тус тус хүргүүлнэ.

2.1.8 Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд тусгагдсан хуваарьт болон хуваарьт бус нислэгийн аяллын дугаар, агаарын хөлгийн маяг,зорилго, нисэн очих/гарах нисэх буудал, нислэгийн цаг өөрчлөгдсөн болон хойшилсон, цуцалсан, нэмэгдэл нислэгийн мэдээг холбогдох тайлбарын хамт НМҮБ-д ZMUBZPZX, ZMUBZPZI, ZMCKZPZX, ZMCKZPZI хаягаар дамжуулна.

2.1.9 Томилогдсон мэдээлэгчийн хангах нисэхийн өгөгдөл нь энэхүү зохицуулалтын баримт бичгийн Хавсралт 1-т тусгасан цагийн хязгаар (timeliness)-ын шаардлагыг хангасан байна.

2.1.10 Томилогдсон мэдээлэгч нь НМҮБ-ыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангахдаа шаардлагатай мета-өгөгдлөөр давхар хангана. Шаардлагатай мета-өгөгдлийг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээлэл дамжуулах программ хангамж, маягтад тусгаж өгч болно.

2.1.11 Томилогдсон мэдээлэгч нь НМҮБ-ыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангахдаа энэхүү зохицуулалтын баримт бичгийн Хавсралт 2-т тусгагдсан хэрэгслийг ашиглана.

2.1.12 Томилогдсон мэдээлэгч нь энэхүү журамд заасан цаг хугацаа, чанарын шаардлага хангаагүй, алдаатай, дутуу, өгөгдөл, дамжуулснаас үүсэх хариуцлагыг хүлээнэ.

2.1.13 Томилогдсон мэдээлэгчийн ашигладаг журамд тусгагдсан утасны дугаар болон цахим хаягт өөрчлөлт орох болон хариуцсан ажилтнууд солигдсон тохиолдолд томилогдсон мэдээлэгч нь НМҮБ-д цахим шуудан эсхүл албан бичгээр мэдэгдэнэ.

2.2 НМҮБ-ын үүрэг хариуцлага, үйл ажиллагаа

2.2.1 НМҮБ нь томилогдсон мэдээлэгчийн ирүүлсэн нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүнийг боловсруулан түгээнэ.

2.2.2 НМҮБ нь шаардлага хангасан нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг хүлээн авсан ч зохих цаг хугацаанд нь боловсруулан түгээгээгүйгээс үүсэх хариуцлагыг НМҮБ хүлээнэ.

2.2.3 Томилогдсон мэдээлэгчээс ирүүлсэн түүхий өгөгдлөөс зөрүүтэй ташаа нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн боловсруулан түгээсэн тохиолдолд НМҮБ хариуцлага хүлээнэ.

2.2.4 НМҮБ-ын ашигладаг журамд тусгагдсан утасны дугаарт өөрчлөлт орсон тохиолдолд Томилогдсон мэдээлэгчид цахим шуудангаар мэдэгдэнэ.

2.2.5 Шуурхай мэдээллийн мэргэжилтэн нь нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагаанд шууд хамааралтай ZBAA, ZBHH, ZBTJ, UIII, UIUU аэродромуудын хаалт, хязгаарлалт, хөрш нислэгийн мэдээллийн бүсийн агаарын хаалганаас эхний илгээх цэг хүртэлх

нислэгийн замын хаалт, хязгаарлалт, хориотой, хязгаарлалттай, аюултай бүс идэвхжсэн талаарх NOTAM-г хүлээн авч дараах байдлаар танилцуулна.Үүнд:

a) Дараах хаягуудаар дамжуулж, бүртгэл хөтөлнө.:

Цахим шуудан	AFS
tpu@mcaa.gov.mn, fpd@mcaa.gov.mn, fpd_office@ncac.mn	ZMUBZGZX

b) Хөрш нислэгийн мэдээллийн бүсэд хамааралтай нислэгийн замын хаалт, хязгаарлалт, хориотой, хязгаарлалттай, аюултай бүсийн тухай NOTAM-д график NOTAM-г боловсруулж НМҮБ-ын www.ais.mn цахим хуудасны "PRE/POST FLIGHT INFO" цэсний "Гадаад NOTAM" цонхонд байрлуулна.

2.2.6 НМҮБ-аас зарлагдсан NOTAM болон SNOWTAM-г зөвхөн дараах байдлаар НҮТА-нд хүргэнэ.Үүнд:

a) НҮТА-ны цахим шуудангийн болон AFS хаягаар;

Цахим шуудан	AFS
tpu@mcaa.gov.mn, fpd@mcaa.gov.mn	ZMUBZGZX

b) www.ais.mn цахим хуудасны "NOTAM" цэсний NOTAM эсхүл SNOWTAM цонхонд байрлуулж;

c) Навигацийн анхааруулга болон шувуудын бөөгнөрлийн тухай NOTAM-д график NOTAM боловсруулж НМҮБ-ын www.ais.mn цахим хуудасны "NOTAM" цэсний NOTAM цонхонд байрлуулж.

2.2.7 Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээг НМҮБ-ын aiszmck@ncac.mn, aiszmub@ncac.mn цахим шуудангийн хаягаар хүлээн авна. Нэмэгдэл нислэгийн мэдээг ZMCKZPZX, ZMCKZPZI, ZMUBZPZX, ZMUBZPZI хаягаар хүлээн авч "Нислэг гүйцэтгэл, бүртгэлийн программ"-д шинэчлэл хийж шалгана. Хэрэв нэмэгдэл нислэгийн мэдээг оруулаагүй болон зөрүүтэй байх тохиолдолд НҮТА-ны 71281602 утсаар холбогдон "Нислэг гүйцэтгэл, бүртгэлийн программ"-д оруулуулах болон холбогдох залруулгыг хийлгэнэ.

2.2.8 Буянт-Ухаа ОУНБ болон "Чингис хаан" ОУНБ-аас нисэн гарах нислэгүүдийн талаар тодруулга шаардлагатай тохиолдолд НҮТА-ны 71281602 утсаар холбогдоно.

2.2.9 Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд тусгагдсан "Чингис хаан" ОУНБ-аас нисэн гарах эсхүл "Буянт-Ухаа" ОУНБ-аас нисэн гарах нислэгүүдийн нислэгийн төлөвлөгөө /FPL/-нд тусгагдсан мэдээлэл нь урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд тусгагдсанаас зөрүүтэй байх тохиолдолд НҮТА-ны Шуурхай төлөвлөлтийн хэсгээс тодруулга авна.

2.3 Нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийн алдаа

2.3.1 Хүлээн авсан нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээс алдаа (ойлгомжгүй байх, чанарын шаардлага хангахгүй байх, шаардлагатай бүх өгөгдлөөр хангаагүй байх гэх мэт) илэрсэн тохиолдолд НМҮБ НМҮ-ний Ерөнхий заавар дахь "Түүхий өгөгдлийг удирдах журам"-ын дагуу томилогдсон мэдээлэгчид мэдэгдэж, алдааг залруулуулна.

2.3.2 Хэвлэн нийтэлсэн нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээс алдаа (үл тохирол, сайжруулах зүйл) илрүүлсэн тохиолдолд НМҮБ томилогдсон мэдээлэгчид мэдэгдэнэ.

2.3.3 Хэвлэн нийтэлсэн нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээс алдаа (үл тохирол, сайжруулах зүйл) илэрсэн мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд томилогдсон мэдээлэгч залруулга бүхий нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг нэн даруй НМҮБ-д дамжуулна.

2.3.4 НМҮБ нь томилогдсон мэдээлэгчээс ирүүлсэн түүхий өгөгдлөөс зөрүүтэй, ташаа нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн боловсруулсан тохиолдолд томилогдсон мэдээлэгч энэ талаар НМҮБ-д болон АБЧУГ-т sgmd@ncac.mn цахим хаягаар мэдэгдэнэ.

2.3.5 Нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүнд нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээлэлтэй холбоотой алдаа (үл тохирол, сайжруулах зүйл) илэрсэн талаарх мэдэгдэл томилогдсон мэдээлэгчээс хүлээн авсан тохиолдолд НМҮБ нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүнийг нэн даруй залруулна.

2.4 Нөөц төлөвлөгөө

2.4.1 Түр шинж чанартай, NOTAM болон Шуурхай мэдээгээр зарлах нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг дамжуулах үндсэн хэрэгсэл болох Raw Data программ ажиллахгүй байгаа тохиолдолд дараах хэрэгслийг ашиглана. Үүнд:

a) AFS сүлжээ: ZMUBYNYX, ZMZZNAXX

b) цахим шуудан: notam@ncac.mn;

c) утас: 976-71287131;

d) факс: 976-71283438.

2.4.2 Цахим шуудан, факсаар нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээлэл дамжуулахдаа энэхүү зохицуулалтын Хавсралт 3 дахь маягтыг ашиглана.

3. БУСАД

3.1 Журмын хэрэгжилтийг үнэлэх

3.1.1 Талуудаас томилогдсон удирдах албан тушаалтнууд журмын хэрэгжилтэд жилд нэг удаа үнэлгээ хийж, баримтжуулна.

3.1.2 Талууд журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ба илэрсэн үл нийцлийг залруулах, дахин давтагдахаас сэргийлэх зорилгоор тохирох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

3.2 Үл нийцлийг мэдээлэх

3.2.1 Томилогдсон мэдээлэгч нь журмын заалтуудыг зөрчсөн тохиолдолд Нислэгийн урсгал төлөвлөлтийн томилогдсон мэдээлэгчийн үндсэн хариуцагчид мэдэгдэнэ. Үндсэн хариуцагчид мэдэгдсэн ч зохицуулалтын заалтыг зөрчсөн хэвээр байгаа тохиолдолд хоёрдогч хариуцагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.2.2 НМҮБ нь журмын заалтуудыг зөрчсөн тохиодолд НМҮБ-ын үндсэн хариуцагчид мэдэгдэнэ. Үндсэн хариуцагчид мэдэгдсэн ч журмын заалтыг зөрчсөн хэвээр байгаа тохиолдолд хоёрдогч хариуцагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.3 Журмыг хариуцагчид

Байгууллага	Үндсэн хариуцагч	Хоёрдогч хариуцагч
НМҮА	Д.Үлэмж НМҮА-ны дарга Утас: 71283131 Ц/ш: ulemj@ncac.mn	Д.Баяртогтох АНҮГ-ын дарга Утас: 71283000 Ц/ш: bayartogtokh@ncac.mn
НҮТА	Т.Батбаяр НҮТА-ны дарга Утас: 71285086 Ц/ш:batbayar.t@ncac.mn	

3.4 Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.4.1 Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг талууд албан бичгээр гаргана.

3.4.2 Саналыг журамд 1.2.1 дэх удирдах ажилтнууд харилцан зөвшилцсөн тохиолдолд талууд журамд нэмэлт, өөрчлөлт оруулна.

3.5 Бусад зохицуулалтууд

3.5.1 3.6 хэсэгт тусгагдсан томилогдсон мэдээлэгч өөрчлөгдсөн, шинээр нэмэгдсэн, хасагдсан тохиолдолд briefing_ais@ncac.mn цахим шуудангаар НМҮБ-д мэдэгдэнэ.

3.5.2 Албан хэрэгцээнд ашиглагдах нислэгийн зураг шаардлагатай тохиолдолд хяналттай эсхүл хяналтгүйгээр авах нөхцөлийг тодорхойлсон хүсэлтийг НМҮБ-д албан тоотоор хүргүүлж, хэвлүүлнэ.

3.6. Томилогдсон ажилтнууд

Нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээлэл	Томилогдсон мэдээлэгч	НМҮБ
Түр шинж чанартай, NOTAM мэдээгээр болон шуурхай мэдээгээр зарлах өгөгдөл,	Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн Утас: 71282213 Ц/ш:fpd@mcaa.gov.mn Агаарын зайн мэргэжилтэн Утас: 71283265 Ц/ш:tpu@mcaa.gov.mn AFS: ZMUBZGZX, ZMUBYAYX	ШМХ-ийн шуурхай мэдээллийн мэргэжилтэн Утас: 71287131, 71287282 AFS: ZMUBYNYX, ZMZZNAXX Ц/ш: notam@ncac.mn

ХАВСРАЛТ 1 - ЦАГИЙН ХЯЗГААР (TIMELINESS)

1. NOTAM болон шуурхай мэдээ зарлагдах өгөгдлүүд нь дараах цаг хязгаарын шаардлагыг хангасан байна. Үүнд:

   a) эвдрэл, гэмтэл, саатал гарсан тохиолдолд өгөгдлийг эвдрэл, гэмтэл, саатал гарснаас хойш аль болох богино хугацаанд НМҮБ-д дамжуулна;

   b) урьдчилан төлөвлөсөн арчилгаа, цэвэрлэгээний ажил хийх тохиолдолд өгөгдлийг ажил эхлэхээс 30 минутын өмнө НМҮБ-д дамжуулна;

   c) урьдчилан төлөвлөсөн техник үйлчилгээ, засварын ажил хийх тохиолдолд өгөгдлийг ажил эхлэхээс 2 цагийн өмнө НМҮБ-д дамжуулна.

ИНУТ-АБЧУГ №01
ХЯНАЛТТАЙ

ХАВСРАЛТ 2 – НИСЭХИЙН ӨГӨГДӨЛ, НИСЭХИЙН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ХЭРЭГСЭЛ

1. Түр шинж чанартай богино хугацаатай NOTAM эсхүл шуурхай мэдээгээр зарлагдах нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг дамжуулах үндсэн хэрэгсэл нь Raw Data программ байна.

1.1. Raw Data программд https://rawdata.ais.mn/ холбоосоор хандана.

1.2. НМҮБ нь Raw Data программд хандах хэрэглэгчийн нэр, нууц үг болон программ ашиглах зааврыг цахим шуудангаар томилогдсон мэдээлэгчид хүргүүлнэ.

1.3. Томилогдсон мэдээлэгч нь Raw Data программтай холбоотой лавлагааг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны Тоон мэдээллийн хэсгийн 71283138 дугаарын утас эсхүл it-ais@ncac.mn цахим шуудангаар хандаж авна.

1.4. Нислэгийн аюулгүй байдалд шууд хамааралтай нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр NOTAM болон Шуурхай мэдээ яаралтай зарлуулах шаардлага гарсан тохиолдолд НМҮБ-ын 71283130, 71287282 дугаарын утсаар дамжуулж болно. Утсаар дамжуулсан тохиолдолд заавал Raw data программаар нөхөж явуулна. Утсаар өгсөн болон Raw data программаар нөхөж өгсөн нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийн цаг хугацаа болон утга нь хоорондоо зөрүүгүй байна.

2. НМҮБ-аас эрхлэн гаргадаг нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүнийг www.ais.mn цахим хуудаснаас авч ашиглана.

ХАВСРАЛТ 3 – ТҮҮХИЙ ӨГӨГДӨЛ ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ

НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА
NOF: Утас: 71287131, Факс: 71283438, AFS: ZMUBYNYX, Цахим шуудан: nofam@ncac.mn
AIP: Утас: 71283202, Факс: 70049838, Цахим шуудан: aip@ncac.mn

МА-ЖУ2-1

ТҮҮХИЙ ӨГӨГДӨЛ ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ

Мэдээлэгч байгууллага: _____ Утас: _____

Мэдээлэгчийн овог, нэр: _____ Факс: _____

Албан тушаал: _____ Цахим шуудан: _____

Гарын үсэг: _____ Хавсралтын тоо: _____

(Цагийг олон улсын цагаар бичнэ)

Эхлэх хугацаа (он сар өдөр цаг:мин)	Дуусах хугацаа (он сар өдөр цаг:мин)	Тусгайлан заасан хугацаа (Цагийн хуваарь)

Мэдээний утга:	AIP-ын лавлагаа (AIP-ын дэд хэсгийн дугаар)

ХАВСРАЛТ 4

RAW DATA ПРОГРАММ АШИГЛАДАГ ТОМИЛОГДСОН МЭДЭЭЛЭГЧДИЙН БҮРТГЭЛ

№	Нэр	Албан тушаал	Холбоо барих утсаны дугаар
1	НУТА	Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн	71282213
2		Агаарын зайн мэргэжилтэн	71283265